

**“ХАРХОРИН” ХК-ИЙН 2020 ОНЫ 04 САРЫН 29 ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

“Хархорин” нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04-р сарын 24 өдөр 14.00 цагаас Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн өөрийн байранд хурлын танхимд хуралдсан болно.

Хурал зохион байгуулах комиссын зүгээс Өвөрхангай аймгийн Хархорин суманд Covid 19 цар тахалтай холбоотойгоор “Хархорин” ХК-ийн 2021 оны 04-р сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хувьцаа эзэмшигчдийг аль болох нэг газар олноор цуглуулахгүй халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан хуралдуулах, хувьцаа эзэмшигч нарт хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой мэдээлэл, баримт бичиг, хурлаас гарах тогтоолын төслүүдийг урьдчилан танилцуулж саналыг нь саналын хуудсаар авах зэрэг халдвар авахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан болно.

Мөн энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг онлайнаар буюу Zoom аппликэйшн ашиглан хуралдуулах боломжийг судлан үзсэн. Хурал Хархорин сумын Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн байранд хуралдахаар товлогдсон. Гэвч компанийн байранд байгаа интернетийн сүлжээний хурд хангалтгүй, тасалдах магадлал өндөртэй байсан. Түүнчлэн сүүлийн 10 жилийн хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирж биечлэн оролцдог хувьцаа эзэмшигчид нь Хархорин сумын иргэд, компанийн одооны болон хуучин ажиллаж байсан ажилчид байдаг. Эдгээр иргэдийн дийлэнх нь өндөр насны, Zoom болон бусад төрлийн программ ашиглан хуралд оролцох нь хүндрэлтэй. Иймд энэ удаагийн хурлыг зайнаас хуралдах программ хангамж ашиглахгүй хуралдуулах нь зүйтэй, харин 2022 оны хурлыг цар тахлын нөхцөл байдал дээрдэхгүй, иргэд хөдөө орон нутагт чөлөөтэй зорчих бололцоогүй байгаа тохиолдолд бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр онлайнаар хуралдуулах нь зүйтэй юм байна гэсэн шийдэлд компанийн удирдлага хүрсэн.

Хурлын бүртгэлийн өдөр буюу 2021 оны 04-р сарын 05-ны өдрөөр тасалбар болгон ҮЦТХТ ХХК-с гаргуулсан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй болон хураангуй судалгаагаар “Хархорин” ХК-ийн 2021 оны 04-р сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий нийт 579 хувьцаа эзэмшигч байгаа, эдгээр хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд нийт 539,515 ш саналын эрх бүхий хувьцаа байна гэж бүртгэгдсэн байна. Ийнхүү нийт 579 хувьцаа эзэмшигч саналаа ирүүлэхээс саналын эрх бүхий нийт 378,146 ш энгийн хувьцаа эзэмшиж байгаа 6 хувьцаа эзэмшигч саналаа саналын хуудсаар ирүүлсэн. Хурлын ирц 70.1% болсон. Ирцийн тайлан дараах байдалтай байна:

д.д	Хуралд оролцсон, саналаа хэрхэн өгсөн	Хувьцаа эзэмшигчийн тоо	Хувьцааны тоо
1	Хуралд өөрийн биеэр хүрэлцэн ирж оролцсон	0	0 (0%)
2	Саналаа саналын хуудсаар ирүүлсэн	6	378,146 (70.1%)
	Нийт	6	378,146 (70.1%)

Компанийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцсонд тооцсон.

2021 оны 04-р сарын 24-ний өдрийн ээлжит хуралд хурлын дарга П.Учрал (утсаар холбогдож оролцсон), “Хархорин” ХК-ийн гүйцэтгэх захирал Р.Саранцэцэг (утсаар холбогдож оролцсон), ерөнхий нягтлан бодогч Д.Дашмаа, нярав М.Шавагцэрэн (тооллогын комисс), услалтын механик Баасаа ах нар оролцсон. ТУЗ-ийн гишүүдээс ТУЗ-ийн дарга П.Бишрэл, ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Амарсанаа, Б.Бүрэн нар гар утсаараа холбогдож (чанга яригч дээр тавьж) оролцсон.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Ганбат

Тус хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2021 оны 03-р сарын 12-ний өдрийн 02/2021 тоот тогтоолоор гаргасан. Хурлын мэдэгдлийг тогтоосон хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн. Мөн хурлын мэдэгдлийг МХБ-ийн цахим хуудсан дээрх “Хархорин” ХК-ийн мэдээлэл хэсэгт байршуулсан.

Хурлыг зарлан хуралдуулах ажлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу хийсэн болно.

Хурал болсон газар: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн өөрийн байр

Хурал болсон он, сар, өдөр, цаг: 2021 оны 04-р сарын 24-ний өдөр 14.00 цаг

Хурлын даргын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: Пүрэвийн Учрал

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
2. Компанийн 2020 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах.
4. Компанийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг банк, санхүүгийн байгууллагаас авах, үүнд шаардагдах барьцаа хөрөнгийн тухай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо, хурлын ирц:

“Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит хуралд тус бүр нэг саналын эрх бүхий 539,515 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж байгаа 579 хувьцаа эзэмшигчдийн санал ирэхээс нийт 378,146 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч 6 хүн саналаа саналын хуудсаар ирүүлж, хурлын ирц 70.1 хувь болсон.

Саналын хуудас хэрэглэсэн эсэх, саналын хуудасны загвар: Хархорин ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03-р сарын 12-ний өдрийн 02/2021 тогтоолын хавсралтаар компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 24-ний өдрийн ээлжит хуралд хэрэглэх

саналын хуудасны загварыг баталж тус саналын хуудсаар санал хураалт явуулсан болно (Компанийн тухай хуулийн 71.1-ийн дагуу).

Хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томьёолол:

Асуудал 1: Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

1-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,146; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

1-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томьёолол: “Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 24-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгож компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсэн болно.

Асуудал 2: Компанийн 2020 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

2-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,146; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

2-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томьёолол: “Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 24-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгож компанийн 2020 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсэн болно.

Асуудал 3: Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах тухай

3-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,146; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

3-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томьёолол: “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02-р сарын 05-ны өдрийн 01/2020 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 24-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгоод “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2020 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 294,144 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2021 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрөв.

Асуудал 4: Компанийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг банк, санхүүгийн байгууллагаас авах, үүнд шаардагдах барьцаа хөрөнгийн тухай

4-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,146; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

4-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд арилжааны банкуудаар дамжуулан олгогдож байгаа ажлын байрыг дэмжих хөнгөлөлттэй зээл болон хөдөө аж ахуйн салбарт хаврын тариалалтын үйл ажиллагааг дэмжсэн хөнгөлөлттэй зээлийг авч “Хархорин” ХК-ийн болон түүний охин компаниудын үйл ажиллагаанд зарцуулахаар тогтоож, хөнгөлөлттэй зээл авах, тухайн зээлийн ерөнхий нөхцөлүүдтэй уялдуулан зээлийн хугацаа, хүүний хэмжээг тогтоох, зээлийн барьцаанд “Хархорин” ХК-ийн болон түүний охин компаниудын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших эрхийг барьцаалах зөвшөөрлийг гүйцэтгэх удирдлагад олгох, үүнтэй холбоотой тогтоол шийдвэрийг гаргах бүрэн эрхийг “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгов.

Асуудал 5: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

5-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо:

ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо СЗХ-ны 2020 оны 880 дугаар тогтоолоор батлагдсан Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журмын дагуу тус хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн зүгээс ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд өгсөн кумулятив саналыг тус тусад нь тоолсон. Ердийн гишүүнд нэр дэвшиж байгаа 6 нэр дэвшигчдэд нийт 2,268,876 кумулятив санал ирсэн. Нэр дэвшигч тус бүрд өгсөн саналыг тоолж үзэхэд нэр дэвшигч тус бүрд 378,146 санал ирсэн.

Хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа 3 нэр дэвшигчдэд нийт 1,134,438 кумулятив санал ирсэн. Эдгээрийг нэр дэвшигч тус бүрээр тоолж үзэхэд хараат бус гишүүнд нэр дэвшигч тус бүр 378,146 санал авсан байсан. Ийнхүү саналаа өгсөн хувьцаа эзэмшигчид нь өөрсдийн кумулятив саналыг нийт 9 нэр дэвшигчдэд тэнцүү хуваарилж өгсөн байсан. Түдгэлзсэн санал гараагүй болно.

5-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-г удирдлага болгон “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн:

Нэг. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр Сандагийн Амгалан, Баатарын Амарсанаа, Баттулгын Бүрэн нарыг томилов.

Хоёр. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Пүрэвийн Бишрэл, Жаргалын Энхтөр, Цэрэндолгорын Энх-Амгалан, Пүрэвийн Учрал, Ойдовсүрэнгийн Төмөрбаатар, Лхагвасүрэнгийн Хосбаяр нарыг томилов.

Бусад асуудал хэлэлцсэн эсэх: бусад асуудал хэлэлцээгүй болно.

Хурал өндөрлөсөн: 15.40 цагт

Хурлын дарга



П.Учрал